

Орон бүхний "проектар" нар нэгдэгтүн! АНХ ДЭГТААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 61 (2325) 1974 оны 8 дугаар сарын 15 ПҮРЭВ

МАЛ ЭРҮҮЛЖҮҮЛЭЛТ

Тус аймгийн мал эмнэлгийн байгууллагын материаллаг бааз улам бэхжиж жилд давхарласан тоогоор 3,0 сая малд урьдчилан сэргийлэх тарилга, туулгалт угаалга, боловсруулалт 1,0 сая шахам малд шинжилгээ хийж, эмчилгээ-тэжээлийн цэг 23, сум дундын оношлох кабинет 7 ажиллаж байгаагаас гадна энэ оноос эхлэн бригад малын их эмч ажиллуулж зөвхөн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд улсын хөрөнгө оруулалтаас жил бүр 600—800,0 мянган төгрөгийн био-тарилга авч нэгдэл, САА-д үнэ төлбөргүй олгож байна.

Энэ оны эхний хагас жилд 1 сая гаруй малд урьдчилан сэргийлэх тарилга хийж, эмчилгээ-тэжээлийн цэгт бүгд 30 мянгаад мал эмчлэн 60 хувийг нь эдгэрүүлснээр малын өвчнөөр хорогдох явдал өнгөрсөн оны эхний хагас жилийнхээс 24,4 хувиар багасав. Мал эрүүлжүүлэх материаллаг баазыг бэхжүүлэх талаар Лүн, Заамар, Өндөрширээт, Бүрэн зэрэг сумд онцгой анхаарч эмчилгээ тэжээлийн цэгээ өхижуулж Баян, Өндөрширээт сумд урьдчилан сэргийлэх арга хэмжээг графикт хугацаанд нь чанартай хийжээ.

Гэвч зарим нэгдлийн удирдлагууд мал эрүүлжүүлэх ажлын ач холбогдлыг дутуу үнэлж түүнийг зөвхөн малын эмч нарт найдаад, удирдах зохион байгуулах, шалган туслах арга хэмжээг хангалтгүй авч байна. Тухайлбал Баянцагаан суманд тэмээний хамуу жил дараалан гарч байсныг эмчлэн эдгэрүүлэх талаар аймгийн мал эмнэлгийн газраас шаардах хуудас өгсөн боловч түүний мөрөөр ямар ажил зохиосон нь тодорхойгүй байна.

Ихэнх сум-эмчилгээ тэжээлийн цэг байгуулсан боловч цэгийг тохижуулах, хүчин чадлыг бүрэн ашиглах, эмчилгээний чанарыг дээшлүүлэх талаар мэдэгдэхүйц үр дүн гаргаж чадаагүй байгаа дутагдалдаа дүгнэлт хийж, малын зүй бусын хорогдлыг багасгах талаар МАХН-аас тавьж байгаа зорилтыг биелүүлэхэд бүх нийтийн хүчийг чиглүүлэн малаа эрүүлжүүлэх ажлын арга, зохион байгуулалтыг улам сайжруулах нь чухал байна.

Үүний тулд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг өвчний судалгааг үндэслэн хуваарилж Говь—алтай аймгийн туршлагаар тусгай уналга хөсөг, хоол хүнс бүхий бригад зохион байгуулан аймгийн хэмжээгээр нэгэн зэрэг эхлэн чанартай хийж байх журмыг тогтоох нь зүйтэй.

Малын угаалга тарилга туулгалт шинжилгээ, боловсруулалтыг явуулах тухай сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны шийдвэр гарган, явч чанартай байнгын хяналт шалгалт хийх хэрэгтэй.

Ялангуяа хамуунаас урьдчилан сэргийлэх намрын угаалгыг чанартай хийж, түүнд бүх тэмээ, үхэр, бог малыг хамруулахаас гадна ил хамуу өвчтэй малыг гардан эмчлээд 1 жилийн хугацаагаар хязгаарлалтын арга хэмжээнд авч, малын хөдөлгөөн хийхийг хориглох ёстой.

Одоогийн байдлаар нилээд суманд бог малын догол өвчин гарч байгаад дүгнэлт хийж өвчтэй малыг цуглуулан эмчлэх сууриудыг хуурай нутагт нүүлгэх, ариутгал хийх зэрэг ажлыг шуурхай хийж эмийн фондтой болох нь чухал байна.

Малд сар тутам үзлэг явуулж өвчтэй малыг 14 хоног тутам эмчилгээ-тэжээлийн цэгт цуглуулан мал бүрт өвчний түүх бичиж, эмчилгээг тогтмол хийж цэгийг үр ашигтай ажиллуулах хэрэгтэй. Мал эрүүлжүүлэх ажилд мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын хүчийг зөв зохион байгуулан, тэдний ажлыг шалган зааварлах, ажилд нь туслах, үүрэг амлалт авахуулан дүгнэх, болзолт уралдан зарлан урамшуулах, туршлага солилцуулах, энх сүрэгтийн хөдөлгөөнийг өрнүүлэн сар улирал жилээр шалгаруулах мэргэжилтний тавьсан асуудалд анхааралтай хандаж тодорхой ажил зохиох зэргээр мал сүргээ эрүүлжүүлэх явдал орон нутгийн нам, улс, ХАА-н байгууллага, хариуцлагатан, мэргэжилтний нэн чухал зорилт болж байна.

ТӨЛӨВЛӨГӨӨТ ТАВАН ЖИЛИЙН ГАВШГАЙЧ

Ур шаардах мэргэжил

Даавуугаар хувцас эсгэхтэй адил модоор унь, тооно, ширээ, шүүгээнээс эхлээд мужаануудын хийдэг болгочыг эсгэх ярвигтай мэргэжлийг С. Агваанлуvsан гуай эзэмшээд удаан жил ажиллаж зузаан туршлагатай болжээ.

С. Агваанлуvsан гуайтай уулзаж ярилцахад модны эсгүүр урих шаардлаг ажил даа.

Ур ухаан гарган байж «долоо хэмжиг нэг зурсан» шугамаараа ямарч модыг согоггүй эсгэж болдог гэлээ.

С. Агваанлуvsан гуай нарийн мужааны V зэрэгтэй бөгөөд мужааны эсгүүр хийхийн тулд алх харуулаас эхлээд Ойн аж ахуйн модон эдлэлийн төвийн тасагт буй цахилгаан хөрөө, өрөм хүртэл бүхий л багаж техникүүдийг эзэмшжээ.

Багаж техникийнхээ хувийг хором алдалгүй ашиглан ажилласнаар өдрийн нормоо ажлын 6 цагт хийж үлсэн 2 цагт нь маргаашийнхаа ажлаас амжуулан сарын төлөвлөгөөг сараас нь өмнө, удирдлынхыг удирлаас нь өмнө амжуулж уралдаанд хошуучлан V таван жилийнхээ төлөвлөгөөг 1 жил 6 сарын өмнө 103 хувиар биелүүлээд үлдэж буй хугацаанд 2 жилийн ажил хийх зорилт тавиад ажиллаж байна.

Ш. ЦЭРЭНДОО

ХАДЛАНГИЙН ЯВЦ

Аймгийн хэмжээгээр 8 дугаар сарын 12-ны байдлаар 16,6 мянган тонн өвс бэлтгэж төлөвлөгөөний 17,3 хувийг биелүүлээд байгаагийн дотроос САА 22,7, ХАА-н нэгдлүүд 15,6, ТАА-нууд 8,5 хувьтай байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7,6 мянган тонн буюу 84,4 хувиар илүү байна.

Хадлангийн төлөвлөгөөний биелэлтийг сумдаар байр эзлүүлбэл

Байр	Сумд	Хувь
1	Жаргалант	41,2
2	Баянцогт	36,6
3	Баян—Өнжүүл	34,0
4	Өндөрширээт	33,9
5	Заамар	22,7

ЗӨВЛӨЛТ ХОЛБООТ УЛСАД

Зөвлөлтийн төмөрлөгчид ЗХУКН-ын XXIV их хурлын шийдвэрийг биелүүлэн ган хайлуулахын хувьд улс орноо дэлхийд нэгдүгээр сууринд орууллаа.

IX таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилд 277,45 сая тонн ширэм, 377,2 сая тонн ган хайлуулж, 263 сая тонн хар төмөрлөгийн цувимал үйлдвэрлэлээ.

VIII таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилийнхтэй жишихэд 53,5 сая тонн ширэм, 71,6 сая тонн ган, 52,3 сая тонн цувимал илүү үйлдвэрлэжээ.



Эсгүүрчин С. Агваанлуvsан



Эсгүүрчин С. Агваанлуvsан өрөмдөгч суурь машин дээр ажиллаж байгаа нь. Зохиогчийн авсан гэрэл зураг.

6	Баян	19,9
7	Бүрэн	17,9
8	Лүн	17,4
9	Баянзүрх	17,3
10	Баянцагаан	15,3
11	Угтаал	15,2
12	Дэлгэрхаан	13,1
13	Сэргэлэн	11,5
14	Батсүмбэр	10,2
15	Алтанбулаг	10,0
16	Борнуур	9,7
17	Эрдэнэ	9,2
18	Мөнгөнморьт	7,1
19	Эрдэнэсант	6,0
20	Баяндэлгэр	5,6
21	Баянжаргалан	3,4
22	Баянчандмань	3,2

Баянжаргалан, Бүрэн, Мөнгөнморьт, Эрдэнэсант сум графикт хугацаанд мэдээгээ ирүүлээгүй учир хуучин мэдээгээр гаргав.

Статистикийн товчоо



Тус аймгийн Ойн аж ахуйн модон эдлэлийн төвийн тасгийн I ээлжийн ахлагч, мужаан Н. Ядамсүрэн нарийн мужааны IV зэрэгтэй бөгөөд тасгийнхаа аль ч дамжлага дээр ажиллаж чадах хос мэргэжилтэй хүн юм. Тэрээр 1968 оноос эхлэн тус тасагт мужаанаар ажиллах хугацаандаа сар бүрийн нормоо 20—30 хувиар тогтмол давуулж ямагт согоггүй бүтээгдэхүүн гаргадаг амжилтаар хамт олноо үлгэрлэн ажиллаж байна. Н. Ядамсүрэн V таван жилийн төлөвлөгөөг I жил 6 сарын өмнө 100,7 хувиар биелүүлээд байна.

ЗУРАГ ДЭЭР: Мужаан Н. Ядамсүрэн банз захлаж байгаа нь.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ-ийн авсан гэрэл зураг

ЦУТГУУРЧИН БҮСГҮЙ

МХЗЭ—ийн гишүүн А. Чулуунсүх аймгийн Урчуудын салбарын пааландал мал шавар эдлэлийн тасагт цутгуурчнаар ажилладаг.

Тэрээр энэ мэргэжлийг эзэмшээд 8 жил ажиллах хугацаандаа сар, жилийн төлөвлөгөөг тогтмол биелүүлж бүтээгдэхүүний чанарыг сайжруулахын тулд хэвийг дэс дараагаар нь нягт чамбай боосны хойно шаврын нимгэн зузааныг тааруулан цутгаж хэв салгасны дараах заслалыг сайн хийдэг уч-

раас цутгуур эх формын дагуу үзэмжтэй бөх болдог аж.

Цутгуурчин А. Чулуунсүх бүх ард түмний социалист уралдааны жил-1974 онд 2200 төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэх тооцоотой үүрэг авч энэ оны эхний хагас жилийн төлөвлөгөөг 124,8, 7 дугаар сарын төлөвлөгөөг 117 хувиар биелүүлж уралдаанд авсан амлалтаа хэрэгжүүлж 1400 төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлээд байна.

Ц. ШАГДАРСҮРЭН

УЛСЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛҮҮЛЭХ ХАРИУЦЛАГА

Манай аймгийн хөдөлмөрчид МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг угтаж бүх ард түмний социалист уралдааныг өрнүүлэн ажилласны дүнд улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1974 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг зорилтыг амжилттай биелүүллээ. Аймгийн хэмжээгээр 538,3 мянган төл бэйжүүлэн, хаврын тариалалтын төлөвлөгөөг 101,8 хувиар, үйлдвэрийн газрууд бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг 110,1-128,7 хувиар биелүүлсний дотор зам, барилга, тээвэр, холбооны төлөвлөгөөг зорилт амжилттай биелэгдэв.

Хагас жилийн төлөвлөгөөг ажлаар сум, хороодын дотроос Угтаал, Баян-өнжүүд, үйлдвэр аж ахуйн газруудаас Зам ашиглалтын анги, Хүнсний үйлдвэр социалист уралдаанд түрүүлээ. Батсүмбэр, Угтаал, Жаргалантын САА, Эрдэнэсант сум, аймгийн Хүнсний болон Сонини үйлдвэр зэрэг үйлдвэрлэлийг удирдах эдийн засгийн удирдлагыг зохион байгуулалтын удирдлагатай чадамгай хослож, үйлдвэрлэлийн ажиллагаа тогтворжин мэдэгдэхүйц үр дүнд хүрч байгаа үйлдвэр аж ахуй, нэгдэл, САА-н тоо олширч байна. Гэтэл зарим нэгдэл, САА, үйлдвэр, аж ахуйн газрууд улсын төлөвлө-

гөөний сахилга батыг чанд сахиж төлөвлөгөөт үзүүлэлтүүдийг хугацаанд нь нэр төрлөөр жигд хангахад муу анхаарснаас төлөвлөгөө тасалдах явдал байсаар байна.

Статистикийн мэдээгээр ямааны ноолуур, бодын хялгаснаас бусад төрлийн ноосны төлөвлөгөө одоо хүртэл биелэгдээгүй хуулин хугацаа зөрчин, хадлан тариа бэлтгэх чухал ажилд чирэгдэл учруулж байгаагийн дотор Эрдэнэ сум бөх төрлийн ноосны төлөвлөгөөг биелүүлээгүй байна. Түүнчлэн түүхий эд бэлтгэлийн 20 гаруй нэр төрлийн төлөвлөгөө тасарчээ. НААУ-ийн газрын гутал, төмөр эдлэл үйлдвэрлэлт 6,4—31,2, ойн

аж ахуйн зүсмэл материал гаргалтын төлөвлөгөө 13,8 хувиар тус тус тасраад байгаа бөгөөд Худалдаа бэлтгэлийг удирдах газрын нийтийн хоол, соёлын хэлтсийн номын гүйлгээ, НААУ-ийн газрын халуун ус, цэвэр ус борлуулалтын төлөвлөгөө мөн биелэгдсэнгүй.

Энэ бүхнээс дүгнэлт хийхэд улсын төлөвлөгөө биелэгдэхгүй байгаа гол дутагдал нь зарим байгууллагын удирдах нөхдийн ажлын арга барил, эдийн засгийн албаны хүмүүсийн бүтээлч идэвх санаачлага, даалгасан ажлыг хариуцах хариуцлага хангалтгүй, аж ахуйн үйл ажиллагаа үйлдвэрлэлийн үр ашг, чанарын үзүүлэлтэнд хугацаа алдалгүй дүгнэлт хийж тухай бүр арга хэмжээ

авч байгаагүйд оршино.

1974 он бол V таван жилийн төлөвлөгөөний дүн гаргахад онцгой үүрэг хариуцлага бүхий өндөр бүтээлийн жил юм. Иймд нэгдэл, САА, үйлдвэр, үйлчилгээний нийт газар V таван жилийн төлөвлөгөөний урьдчилсан гүйцэтгэлийг тооцон дутууг биелүүлэх талаар ажилчдаар амалт үүрэг авахуулах зэрэг тодорхой арга хэмжээ даруй авах хэрэгтэй.

Эдийн засаг бол намын ажлын гол фронт мөн гэсэн намынхаа дайчин уриан дор ажлын бүх хэсэгт зохион байгуулалтыг хангаж боловсон хүчний хариуцлагыг өндөржүүлэн улсын төлөвлөгөөний сахилга батыг чандлан сахъя.

Д. ЦЭНД-АЮУШ



Хадлангийн үеэр зохиож байгаа ухуулгын ажил

Тус аймгийн намын байгууллагууд хадлангийн үеэр үзэл суртал зохион байгуулалтын ажлаа МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажилтай холбоон явуулж байна. «Арвин их хадлан бэлтгээ» гэсэн сэдвээр нийт сум, САА, ТАА, ХАА-н нэгдлүүд хөдөлмөрчдийн гэжээрийн хурал бригадын өдөрлөг зохиож үзүүлэх сургууль, семинар хийж хадлан бэлтгэх арга технологийн талаар хичээл зааж нийтийн хүчийг малын тэжээл бэлтгэхэд чиглүүлж байна. Батсүмбэр, Заамар, Эрдэнэсант, Жаргалант, Угтаал сумдын нам, олон нийтийн байгууллага ухуулга суртал нэвтрүүлгийн ажлыг хадлангийн талбайд төвлөрүүлэн тасаг, бригад, салаа, хэсэг нэг бүрт ухуулах байр булан байгуулан хадланг чанартай, богино хугацаанд бэлтгэх арга технологи, тэргүүний хадланчдын туршлагыг самбар, зурагт хуудсаар үзүүлэн тайлбарлах, радио чанга яригчаар сонсох, социалист уралдааны болзолыг өдөр тутмын ажлын норм, үнэлгээ цалин хөлстэй нь холбон тайлбарлах, зураг схемээр үзүүлэх зэрэг олон төрлийн ажил зохиож байна.

1974 онд ургац хураалтын талаар социалист уралдаан өрнүүлэх тухай МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв Зөвлөл, МХЗЭ-ийн Төв Хорооны тогтоолыг нийт хөдөлмөрчдийн цуглаанаар хүлээн авч 1972 оны хадлан тэжээл, үр тариа, төмс, хүнсний ногоо хураах төлөвлөгөөг давуулан бие-

лүүлэхээр социалист уралдаанд 12 тасаг, 32 салаа, 49 бригад нэмэлт үүрэг авлаа. Атар газар эзэмшсэний 15 жилийн ой угтсан уралдаан өрнүүлэн атрын нэрэмжит салаа, бригад зохион байгуулж ухуулагчдыг хадлан дээр нэмэгдэл үүрэгтэй ажиллуулж манлайлалыг 5,7 хоногоор дүгнэх, ухуулах хуудас, ханын сонин, дохио, лавлах дэвтэр, асуулт хариултын хайрцаг аялуулин хадланчдын санал хүсэлтийг авч зөвлөлтөгөөг арга хэмжээ авч байна. Эрдэнэсант, Заамар, Эрдэнэ, Баяндэлгэр, Мөнгөнморьт сумдад хадланчдын бригад, салаагаар албан газрууд шөвлөн авч хүн хүчээр туслах механикч-инженер, хүний эмч, дуучин, хөгжимчин, кино мөхөөрч, худалдагч, үсчин оролцсон ухуулан сурталчлах бригадыг ажиллуулж байна.

Борнуур, Угтаал, Батсүмбэр, Баянцогтын САА-н нам, олон нийтийн байгууллагууд хадлангийн талбайгаар аялан явах ухуулгын байрыг авто машин дээр тоноглон тохижуулж түүндээ хадлан, малын тэжээл бэлтгэх төлөвлөгөө биелүүлэх аргачлалыг сурталчилсан самбар, ном, сонин, шатар, даам, соёл

ахуйн бүхий л үйлчилгээтэй явуулж байна.

Энэ жил аймгийн хэмжээгээр хадлан дээр 120 гаруй ухуулагчид ажиллаж байгаагийн 70 шахам хувь нь ухуулга суртал нэвтрүүлгийн ажилд туршлагатай болсон хүмүүс юм. Хадлангийн ажил нь богино хугацаанд шуурхай явуулах шаардлагатай тул ухуулга, соёл хүмүүжлийн ажлыг амралтын чөлөө цагт товч тодорхой ойлгомжтой хийж төрөл бүрийн тоглоом биеийн тамирын тэмцээн, үлэшил, уулзалт зохиож тэргүүний хадланчдын туршлагыг дэлгэрүүлж байна. Эрдэнэсант, Заамар, Жаргалант, Угтаал, Баян-өнжүүл сумдын нам, байгууллага хадлан бэлтгэх бригад, салаадын дэргэд ээлжийн ухуулагчид ажиллуулан нэгдэл, САА, тасаг, бригадын хариуцлагатан удирдах хүмүүсийг ухуулгын ажилд оролцуулж байна.

Заамар нэгдлийн нам, олон нийтийн байгууллагууд хадлангийн бригад аялан чөлөө цагаар түр цуглаан хийж тэргүүний ээлж, бригад, тракторчдад туг дарцаг, мөнгөн шагналыг байгуулгын захидал, баярын бичиг гардуулах, улс төрийн сонсгол хийх, захиалсан хэвлэлийг тараах зэргээр ажиллаж байна.

Ингэж тус аймгийн нам, улс, олон нийтийн байгууллагууд ухуулга суртал нэвтрүүлгийн ажлыг хадлангийн ажилд чиглүүлж байна.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

300 тонноор давуулна

Баянцогтын САА-н Н. Түвдэнсүрэн даргатай хадлангийн механикжсан салаа 2000 тонн өвс бэлтгэх төлөвлөгөөг 300 тонноор давуулан биелүүлэх үүрэг авч эхний арав хоногт мянга шахам тонн өвс хадгаж, тармаж, хаман боож төлөвлөгөөгөө давуулан олон арван төгрөгийн шатахуун сэлбэг хэрэглэл хэмнэлээ.

Тус бригадын тракторчин Н. Болдбаатар, Базаргачаа нар өдөр бүрийнхээ төлөвлөгөөг 140-180 хувь биелүүлэн түрүүлж явна.

О. СУМБЯА

Монголын радиогийн 40 жилийн ойн өмнө

Зай зайгаа авсан жагсаал олон модны оройгоор сунайлган татсан шугамын нэгэн хэсгээр нь өндөр хүчдэлийн цахилгаан, нөгөө хэсгээр нь дууны долгион урсан байна.

Хүмүүсийн дуугаар амилан зүрхний олон судас мэт зүг зүгт салбарлан Зуунмод хотын албан контор, үйлдвэрийн тасаг цех, айл гэрийн хоймо-роос хангинаж буй цаасгүй сонинны шугам даган энэхэн сурвалжлагаа эхэллээ.

Аймгийн Холбооны газрын радио узелийн «СТ-808» өсгөгчөөс эх авсан гол ба хэрэглэгчийн энэ шугам хосоор 23 км үргэлжлэхдээ 964 цэгт шугамын чанга яригч хангинуулж байна.

1973 оны өвлийн өвгөн аавын хүндэт үгийг энэ шугамаар Зуунмод хотын 781 цэгт хүмүүс сонсч байсныг радио тасгийн хамт олон дараа оны өвгөн ирж баярын үгээ хэлэхэд 1000 цэгээр дамжуулах зорилт тавиад ажилласан бөгөөд одоо тус хотын 2,5 дугаар хороо, Зүүндэлгэр дэх малчдын хороо хүртэл радио шугамыг 12 километрээр уртасгах бэлтгэл ажлаа амжуулжээ.

Шугам даган сурвалжилж явахад радио тасгийнхны ажлын бүтээлийг

илтгэж, хэрэглэгч олныхоо таашаал хүлээсэн хэд хэдэн шинэ зүйл сонирхол татлаа.

Радио шугамын засвар хийж яваа монтёр С.Дагвыг утасны модноос бууж ирэхэд нь уулзаж та радиогийнхөө 40 жилийн ой угтаж хийж байгаа ажлаасаа ярьж өгнө үү гэхэд:

— Миний гол ажил бол радио шугамын гэмтлийг хамгийн түргэн хугацаанд илрүүлэн засах явдал юм.

Ийм учраас би гэмтэл илрүүлэгч багажийг богино хугацаанд сайтар эзэмшин ажиллаж байна.

тэргүүн туршлага эзэмшиж, 9 вольтын шулуутгагч 20-нодыг хийж шинэ санаачлага, телевизийн антеннийн өсгөгч хийж оновчтой саналд бүртгүүлээд байгаа.

Та заавал түүнтэй уулзаарай гэв.

Тэндээс аймгийн Холбооны газар гэсэн хаягтай цагаан байшинд ороход радио хоолой хангинан, хөвлөл шуудан зөөсөн хүмүүсийн хөл тасралтгүй цувсаар байлаа.

Тэнд радио тасгийн узель харуцсан ахлах техникч Б. Батсүрэнтэй уулзав. Намын гишүүн Б.Бат

лийн ой угтаж танай тасгаг юу хийж байна гэж асуухад тэрээр ингэж ярьв. Манай тасаг радио засварчин, операторчин, телевизийн болон, сувгийн техникч, монтёр зэрэг мэргэжлийн 8 хүнтэй.

Бид оны эхнээс Монголын радиогийн 40 жилийн ой угтсан уралдаан өрнүүлэн хүн бүрээр үүрэг амлалт авахуулж гүйцэтгэлийг сар бүр дүгнэж ажилласны үрээр тасгийн төлөвлөгөө нэр төрөл бүрээр тогтмол 114—157,7 хувиар биелж ирлээ.

Саяхан дүгнэсэн урал-

угтаж Өндөрширээт, Мөн-генморьт суманд 30-аад цэгтэй радио узель шинээр тавьсны гадна хэд хэдэн суманд узелийн цэгийн тоог нэмж Монголын радиогийн 40 жилийн ой угтаж зарласан уралдааны болзлыг биелүүлэхэд нь мэргэжлийн тусалцаа үзүүлээ.

Радио тасаг дотроо узелийн өсгөгч «СТ-808»-ийн гэмтэлийг байсан 4 блокыг сэлбэж ажилд оруулснаар төвийн радио өргөн нэвтрүүлэг дамжуулахад гарч байсан саатлыг урьд оныхоос 50 хувь багасгалаа.


Манай хотынхон оны эхэнд телевизийн нэвтрүүлгийг 224 цэгт үзэж байсныг 300-д хүргэх зорилт тавиад 259 хүргээд байна гэж ярьв.

Эдний тасгийнхан бүгд СХБ-ын гавшгайчид бөгөөд III алдар медалийн төлөө үүрэг аваад ажиллаж байгаа аж.

Аймгийн Холбооны газрын радио тасгийнхан үлдэж байгаа хугацаанд авсан амлалтаа давуулан биелүүлж хөдөлмөрчин олноо радиогоор үйлчлэх үйлчилгээг улам сайжруулж Монголын радиогийн 40 жилийн ойд хөдөлмөрийн өндөр амжилтаар бэлэг барихаар шамдагцаж байна.

Ш. ЦЭРЭНДОО

ШУГАМ ДАГАЖ ХИЙСЭН



Нөгөө талаар радиогийнхөө 40 жилийн ойг угтаж гэмтэл хязгаарлагч резетик санаачлан хийлээ гэж ярихад бидний ярилцахыг сонирхож байсан нөхдийн нэг нь таны санаачлан хийсэн энэ резетик туйлын ашигтай зүйл юм. Гэмтсэн нэг цэгийг согго бусад цэгүүдэд нөлөөлж хэрэглэгчдийг холироодог явдлыг арилгах чадсанд бид баяртай байна гэхэд С. Дагва хариу талархал илэрхийлээд манай ахлах техникч Б. Батсүрэн шугамын чанга яригч 10 гаруйг хийж

сүрэн аймгийн Холбооны газрын тэргүүний мэргэжилтнүүдийн нэг бөгөөд 1968 онд тус тасгийг 330-аадхан цэгтэй байхаас нь эхлэн техникчээр 17 жил ажилласан шинийг санаачлагч хүн юм.

Тэр харуцсан тасгийнхаа ажлыг сайжруулах нэг үндэс нь ажилчдаа мэргэжлийн талаар туслах явдал гэж үзэж шинжлэх ухаан техникийн сүүлийн үеийн ололт, радиогийн шинэ бүтээлүүдтэй байнга танилцуулаж ажээ.

Б. Батсүрэнгээс Монголын радиогийн 40 жи-

даанд операторчин Л.Нэргүй, Х. Нина нар төлөвлөгөөгөө 107,3—171 хувиар биелүүлж түрүүлэв.

Түүнчилэн Зуунмод хотынхоо хороодоор радио идэвхтнийг радио цэг нэмэгдүүлэх, гэмтэл илрүүлэн засварлах татвар хураах зэрэг ажлаар уралдуулж мөн сар бүр гүйцэтгэлийг нь гаргаж байна. 7 дугаар сарын уралдаанд III хорооны радио идэвхтэн Равжир, VI хорооны Намхай нар түрүүлээ. Мөн Монголын радиогийн 40 жилийн ой

ХОЛЫГ ЗОРИХ САЙХАН

Олноо цуут Гангын даваа уруудан Шархайн их хөндийн замаар баруун зүг давхиулахуй нар сая л мандаж байв.

Хурд хэмжих зүү нь 40—50-ийн тооны хооронд тогтмол зааж зангь нь авсан унаган хүлэг мэт тэрэгний нь хөдөлгүүр нэгэн хэмээр нүргэлэн хурдалж байлаа.

Шагдар жолооч замаа ширтэн бодолхийлж явнаа тоолуураа хараад энэ онд гүйцэтгэх тонн км-ийн төлөвлөгөө нь биелснийг яг энд олж үзлээ.

Их ойнууд угтан энэ жил 164,2 мянган тонн км явах үүргээ бүтэн таван сарын өмнө 101 хувиар гүйцэтгэсэн аймгийн авто тээврийн XIII баазын жолооч тус баазын дэргэдэх Р.Дамдинсүрэн ахлагчтай саятны бригадын гишүүн С.Шагдарын хөдөлмөрийн нэгэн өглөө ийнхүү эхлэв.

«Эр хүний жаргал эсгүй хээр» гэдэгчлэн энэ хүний жаргал ч мөн л уул талынхаа алс, урт замынхаа аянтай холбоотой ажээ. Цаг хугацаа гэдэг хурдаа авсан тэрэг мэт арилан одно.

ТОВЧХОН

Угтаалын САА-н мал аж ахуйн мэргэжилтнүүд бод малын хээлтүүлгийн ажилд онцгой анхаарал

IV таван жилийн төлөвлөгөө 164 хувиар биелүүлсэн түүний амжилтанд тээврийн хамт олон нь баяр хүргэн амжилт өрөөж байсан нь саяхан мэт авч V таван жилийн төлөвлөгөөний их хөдөлмөрийн жилүүд нэг мэдэхнээ төсгөлдөө ойртож ажил төрлийнхөө хувьд гэвэл ёстой л «Дороо суурьтай» дотроо ухаантай ажилладаг Шагдар жолооч ч жирэлзэн буй цагийн урсгал лугаа өрсөн шамдаг шинэ таван жилийнхээ ажлыг нэгэнт нугалчихаад байгаа гэнэ.

Энэ таван жилд 775,9 мянган тонн км явахаас одоо 26,6 тонн км л үлдээд байна.

Үүнээс би 8 дугаар сард багтаан хийж 1 жил 4 сарын өмнө таван жилийн төлөвлөгөөг биелүүлнэ гэж энэ жолооч ярьж байна. Үүгээрээ тэр одоо гоос зургаан жилийн өмнө хүлээн авч төлөвлөгөөт хоёр жилийн ажлын цаана гарсан авч мөн л шинэхнээрээ мэт үзэгдэх 06—06 номерын «ЗИЛ-130» машинаараа удаах таван жилийн ажилдаа урам зорилгог төгс орох юм.

тавьж гардан хээлтүүлгийн 1 салбар ажилдуулж байгаагийн дээр ердийн хээлтүүлгийн дэвшилтэт аргыг 5 суурьт хэрэглэж бүртгэл судалгааг нарийс

Ийнхүү цаг товчлон ихийг бүтээдэг аргаас нь асуухад техникийн аргачилгааг цагт нь хийж аль ч замд жигд хурдаар явахыг эрхэмлэж 1000 км тутамд хөдөлгүүрийнхээ тосыг сольдог нь хөдөлгүүрийн хэвийн ажиллагаанд нөлөөлдөг тухай зэргээ яриад даацыг нэмэгдүүлэхийн үүднээс хаягдал ашиглан чиргүүл 1-ийг хийж чирч байгаа, резин дугуйг хэмнэх бүхий л бололцоог хэрэглэн зөвхөн сүүлийн хоёр жилд 8 дугуй хэмнэсэн зэргээс үзэхэд ихийг бүтээх сэтгэл, даруу нөхөрсөг ааш зангаараа хамт олондоо хайрлагддаг нь ч аргагүй юм даа гэж бодогдоно.

Ард түмнийхээ тулд замын холыг зорьж аавын хүүгийн алдраа Дуурсган явах нь надад юутай ч зүйрлэшгүй аз жаргал байдаг гэж тэр өгүүлсэн юм. Тиймээс холыг зорих сайхан.

Ажил бүтээлийн гэгээн оргилоод бие сэтгэлээр тэмүүлэн зорих сайхаан. Тэр тусмаа зорьсон тэр л өндөрлөгтөө тэмүүлэн хүрнэ гэдэг бүрч сайхан билээ.

Тийм эрмэлзлэл хүч Шагдар жолоочид буй.

Д. ЦОДДОЛ

Малчид хадланчдад зөвлөгөө

ГАР ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ АРГА

Ургамалын гаралтай гар тэжээлийг бэлтгэхдээ төрөл бүрийн ургамалыг хамгийн их шим тэжээл уураг витаминтай үед нь хадаж, түүж аваад хэрчиж сорс, зоодой хийж давсалж дарж нунтаглан хатаах зэргээр бэлтгэж нар борооноос хамгаалсан тусгай агуулахад хадгална. Ургамалын гаралтай гар тэжээлээр өвөл, хаврын улиралд мал тэжээхдээ бутлан жижиглэх дэвтээх, ургуулах, соёолуулах, ханд, зутан, агшаамал байдлаар бэлтгэж малд өгөх нь илүү ашигтай.

Агшаасан шар будаа Шар будааны агшаамалыг зун намрын улиралд бэлтгэхдээ 10 литр өтгөн буюу шингэн сүүнд 2 кг шар будаа хийж, зөөлөн талаар буцалгаж агшаана. Агшаасан будаагаа хүрээ бүхий хавтгай дэлгэц дээр тавьж сүүдэрт хатаана.

Чийггүй, бүрэн хатсан дараа нунтаглаж савлаад чийггүй байранд хадгална. Шар будааны агшаамалыг жилбэ муутай төлдөсөн малыг тэжээхэд ашигтай.

Мангирын сорс Зун 7—8 дугаар сард мангир хэрчиж жижиглээд аарч хивэгний аль нэгтэй хольж базах буюу

ямар нэг хэвэнд хийж шахаад сүүдэрт дэлгэж хатаана. Таана хөмүүлийг 7 дугаар сараас 8 дугаар сарын дунд үе хүртэлх цэцэглэлтийн хугацаанд түүж сорс, зоодой хийж нөөцөлнө. Таана хөмүүлийн зоодой сорсыг гарар бэлтгэх, түүж цуглуулсан таана хөмүүлийг нуухаж няцлаад шүүсэнд нь багсарч зоодой бэлтгэх ба эсвэл хэрчиж жижиглээд хивэг, аарч, давс, хужиртай хольж сорс хийнэ.

Агийн ханд

Агийг аль ч улиралд бэлтгэх боломжтой боловч ургац шим тэжээл ихтэй үе нь зуны сүүл сар, намрын эхэн сард байдаг учир энэ үед бэлтгэж нөөцлөх хэрэгтэй.

Агийг бэлтгэхдээ 10 литр усанд 1-1,5 кг хэрчиж жижиглэсэн аг хийж сайтар буцалган бор хүрэн өнгөтэй болтол хандаж дээр нь нэг литр тутамд 10 грамм давс нэмж ядарч доройтсон хонь, ямаанд өдөрт 500 граммаас нэг литр хүртэл өгнө.

Мөн агинь хандыг өвс, амьтны гаралтай зарим тэжээлтэй хольж хачирлалал мал амтархан иддэг байна.

Л. ГАННМАА



Хөдөлмөрчдийн хууль Зүйн мэдлэгт

1975 онд болох улсын багш нарын зөвлөлтөөн, Монголын пионерийн байгууллагын 50 жилийн ой угтсан ажил сургууль, багш нарын дунд өрнөж өсвөрийн үеийг сурган хүмүүжүүлэх ажилдаа шинэ шинэ санаачлага гарган амжилттай хөдөлмөрлөж байна.

Манай энэ ололт амжилтын хажуугаар насанд хүрээгүй хүмүүсээс гэмт хэрэг хэв журмын зөрчилд өртөх явдал үзэгдэж байна. Ийм учраас хүүхэд багачуудыг гэмт хэрэг хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар улс, олон нийтийн байгууллага, үйлдвэр албан газрууд, сургууль багш, эцэг эхчүүдээс дор дурьдсан ажлуудыг зохиох хэрэгтэй юм. Үүнд:

Дунд сургууль бүр САА, нэгдлээ түшиглэн сурагчдын хөдөлмөр амралтын зуслан байгуулан ажиллуулахын тулд сурагчдын үйлдвэрлэлийн байнгын бригадтай болох нь чухал байна.

Аймгийн төв, нэгдэл, САА-н төв зэрэг газруудын ОСГ-ны хороолол,

албан байгууллагын ажилчдын нэгдсэн байранд хүүхдийн тоглоом биеийн тамирын талбай байгуулж ажиллуулах нь зүйтэй. Үйлдвэр албан байгууллага, соёл үйлчилгээний газрыг түшиглэн сурагчдын дугуйлан, клуб, нийгэмлэг, чуулга байгуулан хичээллүүлэх нь хүүхдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй

хай» МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс саяхан гаргасан 44 дүгээр тогтоолын заалт ёсоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хот, суурины гудамж замын хөдөлгөөний дүрмийг хүмүүжлийн ажлаар зааж судлуулах, хүүхдийн цэцэрлэгүүдэд хөдөлгөөний аюулгүй байдлыг харуулсан тоглоом, сургалтын материалар дамжуулан хүүхдийг зорчин явах дэг журамд хэвшүүлэн сургах зорилт тавигдаж байна. Эцэг эх бүхэн нам, засгийнхаа

гын төрөл бүрийн хэлбэрээр сурталчлах ёстой.

Багачууд сурагчдын чөлөө цагийг зөв зохистой өнгөрүүлэх хуваарь, графийг анги, бүлэг, айл өрх бүрт гаргаж түүнийг биелэлтэнд тогтмол хяналт тавьж байвал зохино. Өрх бүр 80х120 см-ийн харьцаатай картон буюу модон самбар хийж, түүндээ сурагчдын дүрэм, өдрийн цагийн хуваарь, ариун цэврийн дүрэм, хүүхдүүдийн гэртээ хийх дежурин хуваарь, та үүнийг мэдэх үү?, таны сонирхолд, радио—телевизийн

уламжлал болгон зохиож байвал зохино.

Сургууль, эцэг эх бүр гэмт хэрэг, хэв журмын зөрчилд холбогдож болзошгүй сурагчид, хүүхдийн судалгааг товч анкетаар бичи, шалтгаан нөхцөлөөр нь судлан гаргаж тэднийг байнгын хяналтанд авч авьяас билэг, сайн талд нь түшиглэн тодорхой ажил зохиож олон нийтийн ажил төмцөн уралдаан зэрэгт оролцуулж байх нь хүмүүжүүлэх асар их ач холбогдол нөлөөтэй юм.

Сургууль, цэцэрлэг, албан үйлдвэрийн газрууд «Эцэг эхийн өдөр»-ийг тогтоож мэргэжлийн хичээлийн багш, хүмүүжүүлэгч, сурган хүмүүжүүлэгч, заах аргачдаар зөвлөлтөө өгүүлэх, сурган хүмүүжүүлэх хичээлийг тодорхой системтэй явуулах, хүүхэд багачууд, сурагчдад шатар даам, 100 буудалт даам болон хөлт тоглоомуудыг сургах нийтийн хөдөлгөөнийг сургууль, цэцэрлэг, албан үйлдвэрийн газар, айл, өрх бүрт өрнүүлэх, хүүхдүүдийн чөлөө цагаар тоглох ширээний том шатар, даамыг сургуулиудын дотор болон гадна талбай, ОСГ-ны хороолол, ажилчдын нэгдсэн байруудад байгуулан ажиллуулъя.

Т. ГАВАА

Хүүхэд багачуудыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлье

өнгөрүүлэхэд чухал ач тустай юм. Ерөнхий боловсролын сургууль бүр дээр хууль зүйн булан танхим байгуулж, 1974-1975 оны хичээлийн жилээс эхлэн хууль зүй сурталчлах өдрийг бий болгож, бага ангид сурагчдын биеэ авч явах соёл, дунд ангид марксист ёс зүйн үндэс, ахлах ангид хууль зүйн үндсэн мэдэгдэхүүн олгох ажлыг системтэй зохион байгуулах хэрэгтэй. Мөн «Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний ту-

хууль зарлиг, тогтоол дүрмүүдийг сайтар судлан насанд хүрээгүй хүүхдэд энгийн үгээр байнга тайлбарлан таниулах байх нь чухал. Ялангуяа «Танхайрагчид, нийгмийн хэв журам зөрчигчдэд хүлээгдэх хариуцлагыг чангатгах тухай», «Согтуурах явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигуудыг эцэг эхчүүд, багш хүмүүжүүлэгч нар багачуудын насны онцлогт тохируулан ухуул-

программ зэрэг зүйлсийг байрлуулан түүнийг нь мөрдүүлж сургах нь зүйтэй. Хүүхэд багачуудыг бүр багаас нь байгаль ертөнц, ан амьтан, мал, эд хогшил, байшин барилгыг хайрлан хамгаалах, арвижуулан өсгөх үзлээр хүмүүжүүлэхийн хамт байгаль хамгаалах сарын ажилд, төлийн, шувууны ургацын баяр, дааганы уралдаан, аялал, 7, 8, 10 дугаар анги төсгөгчдөөр мод тариулах, зүлэг суулгах, олон наст ургамлын үр тариалах зэрэг ажлыг



Газрын дундад тэнгисийн зүүн хэсэгт оршдог Кипр аралд болж байгаа үйл явдал өнөөдөр хүн төрөлхтний анхаарлыг онцгой татсаар байна. 9251

хавтгай дөрвөлжин километр талбай, 645 мянган хүн амтай энэ арал Европын ойрхи болон алс дорнод, зүүн хойт африкийн орнуудтай холбоодог чухал зангилаа юм. Ийм учраас НАТО-гийн түрэмгий эвслийнхэн Кипр улсын тусгаар тогтнолыг алдагдуулан Грекэд нэгтгэн түүнийг Газрын дундад тэнгис дэх Түнийн газар, үл живэгч бааз болгохыг эрмэлзсээр ирсэн юм. 1959 онд Кипрт тусгаар тогтнол олгох тухай Цюрих-лондонд хийсэн хэлэлцээгээр НАТО-гийн 3 орон Ангель, Грек, Турк улсууд Киприйн тусгаар тогтнолыг батлан даана гэдэг нэрийдлээр тэнд цэргээ байрлуулсан явдал энэ орны тусгаар тогтнолыг нь ихээхэн хязгаарлагдмал болгосон билээ.

Түрэмгийлэгчид 14 жил тусгаар тогтносон Кипр улсын тусгаар тогтнолыг нь алдагдуулахын

КИПРИЙН БАЙДЛААС

тулалдвээр оролдон Грек, Турк хоёр омгийн хоорондох цуст мөргөлдөөнийг дэвэргэсээр иржээ. Үүний уршаар 1974 оны 7 дугаар сарын 15-нд Кипрт байсан Грекийн офицерууд Киприйн хууль ёсны засгийн газрын эсрэг эвэсэгт үймээн гаргаж ерөнхийлөгч Макариосын засгийн газрыг түлхэн унагаасан юм. Кипрт болсон цуст үйл явдал НАТО-гийн тодорхой бүлгийнхний дэмжлэгтэйгээр хийгдсэн нь дайн дэлхийн өмнө улам тодорхой болсоор байна. НАТО-гийн гүрнүүд Киприйн байдлын тухай хэлэлцсэн НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн хуралдаан дээр Кипр дахь байдал тодорхойгүй байна.

Кипрт болж байгаа үйл явдалд НҮБ оролцох ёсгүй гэдгээр шалтаг заан уул явдлыг газар авахуулсаар байсан юм.

ЗХУ болон социалист орнуудын тууштай чармайлтын үрээр Киприйн байдлыг улс төрийн аргаар зохицуулах талаар нийлээд үр дүнтэй арга хэмжээнүүд авагдлаа.

Энэ оны 7 дугаар сарын 20-нд НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн хуралдаанаас Киприйн талаар тогтоол гаргаж Кипр дахь байдлааны галыг зогсоох

тухай шийдвэрлэсэн нь тус орны байдлыг цаашид хэвийн болгоход чухал алхам болсон юм. Энэ тогтоолын үндсэн дээр Кипрт НҮБ-ын цэргийг оруулж Турк, Грекийн цэргийн хооронд байлдааны галыг зогсоох Киприйн талаар Ангель, Турк, Грекийн гадаад явдлын яамны сайд нарын зөвлөлтөөн болж Киприйн байдлыг зохицуулах зарим алхмууд хийгдэж байна.

Гэвч Кипрт болж байгаа үйл явдал сэтгэл түгшүүлсэн хэвээр байна.

Кипрт байлдааны гал зогсоох тухай хэлэлцээрийг Грек, Туркийн талаас байнга зөрчиж байгаагаар барахгүй Турк улс энэ аралд цэргийн байрлалаа улам бэхжүүлсэн тэлсээр байна.

НАТО-гийн бүлгийнхний дотор үнэн чанартаа Киприйн тусгаар тогтнолыг алдагдуулан холбооны улс болгох гэсэн санаа бодол цухалзаар байна. ЗХУ болон социалист орнууд Кипр дахь гадаадын цэргийг гаргаж ерөнхийлөгч Макариосын хууль ёсны засгийн газрыг сэргээн тогтоож Киприйг тусгаар тогтносон улс байлгахын төлөө тууштай тэмцэж байна.

Я. ДАМДИНСҮРЭН

„СИГУДЭК“ ЧУУЛГА



Зөвлөлт Социалист Автономит Коми Улсад дуу бүжгийн «Сигудэк», гэдэг чуулга ажилладаг. Энэ хамтлагийнхан Болгарт зочлон тоглосны гадна удахгүй Варна, Познани, Кракваргийнхан эдийн урлагийг сонирхоно.

Зураг дээр:

(Зүүн тараас) «Сигудэк», чуулгын жүжигчин Ольга Савельева, Наталья Королева нар.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ

ЗАРЛАЛ

Эрдэнэ сумын «Тула» нэгдлийн тракторчин Дорж-гогов овогтой Ганбаатар нь трактор жолоодох эрхийн 13266 номын үнэмлэхээ, Баяндэлгэр сумын харьяат Нацсрэл овогтой Дунжаа нь иргэний 12327 тоот үнэмлэхээ тус тус гээгдүүлсэн тул хүчингүй болгоц.